

164

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД**

2024 оны 05 дугаар
сарын 21-ны

Жаргалант сум

Хяналтын шатанд гомдол гаргагч:

Нэхэмжлэгчийн өмгөөлөгч Боржигон овогт Дэлэгдоржийн Алимаа, регистрь
ПЮ52051067, утас 99439594, Эрхийн үнэмлэхний дугаар 1254

Нэхэмжлэгч: Ховд аймаг, Зэрэг сум, Гүвээ багт оршин суух /ТВ68011969/
Гулзадынхан овогтой Загдаагийн Отгонбаяр, Утас:94454323

Хариуцагч: Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн улсын байцаагч Б.Анхтуяа,

Захиргааны хэргийн давах шатны шүүхийн 2024 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн
221/МН2024/0239 дугаар магадлалыг эс зөвшөөрч нэхэмжлэгчийн өмгөөлөгч Д.Алимаа,
нэхэмжлэгч З.Отгонбаяр дараах үндэслэлээр гомдол гаргаж байна.

1. Нэхэмжлэгч З.Отгонбаяр нь бага насаа эцэг, эхийн гар дээр хүмүүжиж өссөн бөгөөд
1976 онд Ховд аймгийн Зэрэг сумын сургуулийн 1 дүгээр ангид элсэн суралцаад 1983 оны
хавар 7 дугаар ангиа төгсөөд сургуулиас гарсан. Сургуулиас гараад Ховд аймгийн Зэрэг
сумын Хөдөлмөр нэгдлийн 1 дүгээр бригад буюу Бургасан бригадад эцэг, эхийн хамт
нэгдэл тартал нэгдлийн мал маллаж байгаад Дархан уул аймагт Барилгын Техник
мэрэгжлийнм дунд сургуульд суралцаж төгссөн энэ хугацаанд ч гэсэн өвөл зуныхаа
амралтаар зарим үед цаг агаарын хүндрэлтэй чөлөө авч эцэг эх дээрээ ирж мал малалдаг
байсан байна.Энэ байдлыг багын дарга мэддэг байсан тул шүүхэд мал маллаж байсан
тухай тодорхойлолт гаргаж өгсөн ба нэгдэлд ажилж байхдаа хөдөлмөрийн дэвтэр
нээлгэсэн байдаг.

2. Нэхэмжлэгч З.Отгонбаярын малчинаар ажиллаж байсан хугацааг тогтоосон Ховд
аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 12-ны
өдрийн 153/ШШ2020/00324 дугаартай шийдвэр одоо хүчин төгөлдөр байгаа болно.

Өндөр насны тэтгэвэр тогтоох ажиллагаа бол дан ганц нэг талын ажиллагаа буюу
даатгуулагчтай хамааралтай ажиллагаа бус /тухайн иргэний хүсэлтээр шууд шийддэг
ажиллагаа биш/ тус аймгийн нийгмийн даатгалын байгууллагаас тэтгэвэр тогтоолгохыг
хүсэж гаргасан иргэний бүрдүүлж өгсөн үйл баримт материалыг тэтгэвэр тогтоохоос өмнө

165

хүсэж гаргасан иргэний бүрдүүлж өгсөн үйл баримт материалыг тэтгэвэр тогтоохоос өмнө нэхэмжлэгчийн мэдээлэлийг авч үзэх, нягталж шалгалт хийж тэтгэвэр тогтоох эсэхийг эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлэх бүрэн эрх хэмжээтэй цогц ажиллагаа байдаг тул нэхэмжлэгчийг дангаар нь буруутгах үндэслэлгүй.

Тус аймгийн нийгмийн даатгалын байгууллага 3.Отгонбаяраас тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргаж бүрдүүлсэн үйл баримт материал болон 2020 онд анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн шийдвэрийг шалгуулах боломж байсан байхад зохих хуулийн байгуулгад хандаагүй шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсоноос хойш 3 жилийн дараа акт тавьж маргаж байгаа нь хуулийг хүндэтгэж үзэхгүй хууль зөрчсөн байна.

Захиргааны давж заалдах шатны шүүхээс шүүх бол ажилсан жил тогтоодог, нийгмийн даатгалын байгууллага бол тэтгэвэр тогтоодог байгууллага тул илүү олгосон тэтгэвр 9,579,032 төгрөгийг буцааж төлүүлэх тухай" акт тогтоосон нь 3.Отгонбаярын ажилласан жил тогтоосон хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр татгалзах үндэслэлгүй нөлөөлөхгүй гэж үзсэн нь Шүүхийн хухай хуулийг зөрчиж байгаа асуудал гэж үзэж байгаа ба захиргааны ёрөнхий хуулийн 4-р зүйлийн 4-р зүйлийн 4.1-д заасан хууль дээдлэх зарчмыг үгүүсгэж байна.

Мөн Хүчин төгөлдөр байгаа шүүхийн шийдвэр нь Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж, Монгол улсын нэрийн өмнөөс уншигдсан шүүхийн шийдвэр заавал биелэгдэх хатуу заалттай байхад хариуцагчийн гаргасан акт болон тухайн захиргааны байгууллагаас үйл байдал баримтыг хариуцлагатай нягталж хянаагүй бураатай ажиллагааг хамгаалж давж заалдах шатны шүүхээс өөрөө хуулийг буруу тайлбарлаж хууль зөрчиж байна гэж үзэж байгаа болно.

3. Хариуцагч болох Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Улсын байцаагчаас 2022 оны 11 дүгээр сарын 23-н өдрийн 16-07/30 дугаартай "Илүү олгосон тэтгэвр 9,579,032 төгрөгийг буцааж төлүүлэх тухай" акт тогтоосныг нэхэмжлэгч хүчингүй болгуулахаар тус аймгийн захиргааны шүүхэд хандаж тус аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 2023 оны 12 дүгээр сарын 28-ны өдрийн 125/ШШ2024/0001 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаж актыг хүчингүй болгосныг үндэслэлтэй хуулийн дагуу гаргасан гэж үзэж байна.

4. Нэхэмжлэгч 3.Отгонбаяр тэтгэврээ авахаар ирээд акт тогтоосныг мэдэж Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргад өргөдөл гаргасан байдаг.

Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр "Өргөдлийн хариу хүргүүлэх тухай" албан тоотод "Үүссэн зөрчлийн талаар холбогдох хууль тогтоомжийн дагуу уулзалтын тэмдэглэл хөтөлж, сонсох ажиллагаа хийгдсэн болно. Улсын байцаагчийн актаар тогтоосон төлбөрийг барагдуулах нь зүйтэй гэсэн хариу өгсөн.

Гэтэл 3.Отгонбаяр нь Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр сонсох ажиллагаа хийгдээгүй, би гарын үсэг зураагүй гэж мэтгэлцдэг

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дэх хэсэгт бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах зарчимд нийцэхгүй байна. мөн хуулийн 26.1.Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно, 26.2.Энэ хуулийн 26.1-д зааснаар оролцогчоос тайлбар, санал авах ажиллагааг сонсох ажиллагаа гэнэ гэж хуульчилсан байхад 3.Отгонбаяраас тайлбар саналыг авч сонсох ажиллагаа хийгээгээгүй нь нэхэмжлэгчийн хууль эрх зүйн байдлыг дордуулж эрх ашгийг нь зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна

5.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 зүйлийн 11.1-д...Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлнэ,11.2-д.Шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ, мөн хуулийн 120 зүйлийн 1 болон Монгол Улсын дээд шүүхийн 2007 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн тогтоолд "...Энэ зүйлийн 120.1-д зааснаар анхан шатны шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно. Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор:

а/. Түүнийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлнэ.

б/. Давж заалдах болон хяналтын гомдол гаргах эрхгүй.

.." гэж Улсын Дээд Шүүх тайлбарласан байхад захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс хүчин төгөлдөр байгаа анхан шатны шүүхийн 153/ШШ2020/00324 дугаартай шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан гэж үзэхгүй гэж тайлбарлаж байгаа нь тухайн шүүхээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120.4-т зааснаар зохигч ба хэргийн бусад оролцогч шүүхээр нэгэнт шийдвэрлэгдсэн маргааны талаар шүүхэд дахин нэхэмжлэл гаргах буюу шүүхээр нэгэнт тогтоогдсон үйл баримт ,эрх зүйн харилцаа, иргэний хэрэг хянан шийдвэрлэх өөр ажиллагааны талаар маргах эрхгүй

Мөн захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4-д Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр нэгэнт тогтоогдсон..... баримт хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй гэж заасан байхад захиргааны давж заалдах шатны шүүх нотлох баримтыг дахин дүгнэлт хийж үнэлж байгаа нь хууль зөрчиж, хууль буруу хэрэглэсэн гэж үзэх үндэслэлтэй байгаа ба нэхэмжлэгчийн хууль ёсны эрхийг зөрчсөн байна.

6. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 25 –р зүйлд тэтгэвэр тогтоолгоход боловсролын баримт бичиг бүрдүүлэхээр заагаагүй, өргөдөлд тусгах асуудлыг тусгайлан зохицуулаагүй бөгөөд тэтгэвэрийг байцаагч нь өргөдөл болон өргөдөлд хавсаргасан баримтуудыг нягтлан шалгаж шаардлагатай асуудлыг тодруулах үүрэгтэй байдаг.

7.Ажилсан жил ,нийгмийн даатгалыг шимтгэл нөхөн тооцох тухай хуульд иргэн өөрөө хамрагдах боломжтой эсэхийгээ мэдэх боломжгүй. Үүнийг нийгмийн даатгалын байцаагч тухайн иргэн тус хуульд хамрагдах болрмжтой эсэхийг тодорхойлох үүрэгтэй. Тухайн үед малчинаар ажилсан жил хүрэхгүй ба зөрчилтэй гэж гэж үзсэн бол нэхэмжлэгч 3.Отгонбаяр

нь нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх боломжтой байсан ба төлбөрийн акт тавигдахгүй байсан гэж тухайн захиргааны байгуулгыг буруутгаж гомдон маргадаг

8. Мөн тэтгэвэр тогтоох үед 3.Отгонбаярын хөдөлмөрийн дэвтэр нийгмийн даатгал дээр улсаас өгсөн 11 жилийг нөхөн олгосон ажилгааны хувийн хэрэгт байсан тухайн байгууллага хяналт шалгалын ажиллагаагаар илрүүлэх боломжтой байхад 14 хоногын дотор илрүүлж чадаагүй нь нэхэмжлэгч 3.Отгонбаярын буруу биш тухайн нийгмийн даатгалын байцаагчийн буруу болно. 3.Отгонбаяр нь маргаж байгаа жилүүдийг зориуд нууж хуураагүй харин ч хувиараа нөхөн даатгал хийлгэх боломжтой байсан ба одоо энэ нөхцөл хүчингүй болсон тул тухайн иргэн хохироход хүрээд байгаа болно,

9. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 168 дугаар зүйлийн 168.1...Давж заалдах журмаар хэрэг хянан хэлэлцсэн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийгхүчингүй болгоно, мөн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.6 –д....Шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоосон нөхцөлд шүүхийн урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгохоор хуульд заасан нөхцөл байдал 3.Отгонбаярын нэхэмжлэлтэй хэрэгт тогтоогдоогүй болох нь тухайн иргэний хавтаст хэрэгт авагдсан материалаар нотлогддог,

10.Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд зааснаар шүүхийн шийдвэрээр тогтоогдсон үйл баримтанд нийгмийн даатгалын улсын байцаагч акт тавих эрх хэмжээ олгоогүй байна. Учир нь шүүхийн шийдвэр бол хүчин төгөлдөр байгаа нөхцөлд эцсийн шийдвэр байдаг ба үүнийг хэн дуртай нь өөрчлөн дүгнэлт хийх боломжгүй зөвхөн хуулийн этгээд болон иргэн биелүүлэх үүрэгтэй байхаар хуульчилсанг зөрчсөн байна.

11. Мөн нэхэмжлэгч 3.Отгонбаярыг хуурамч баримт бүрдүүлэн санаатай шүүхийн шийдвэр гаргуулсан байна гэж хариуцагч тайлбарладаг боловч 3.Отгонбаярыг гэмт хэрэг үйлдэж хуурамч баримт бүрдүүлэн санаатай шүүхийн шийдвэр гаргуулсан гэж тогтоосон шийдвэр байхгүйн дээр нэхэмжлэгчээс өөрт нь хамааралтай аль нэг баримтыг засварласан, шинээр үйлдсэн гэх зэргээр хуурамч баримт үйлдэж гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал тогтоогдоогүй байхад захиргааны давж заалдах шатны шүүхээс хуурамч бичиг баримт бүрдүүлсэн гэж үнэлсэн нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 –р зүйлийн 1-д заасан Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хүн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй гэсэн зарчмыг зөрчиж байна.

Иймд захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 4-р сарын 09. Өдрийн 221/МН2024/ 0139 дугаартай магадлалыг хүчингүй болгож, давж заалдах гомдлыг хангаж шийдвэрлэж өгнө үү

Давж заалдах шатны магадлалыг 2024 оны 5 сарын 17 нд гардан авсан болно

Нэхэмжлэгчийн өмгөөлөгч



Д.Алимаа

Нэхэмжлэгч

З.Отгонбаяр

З.Отгонбаяр

Дээд мүүхэд эргэдэг газрын нь
 Залдан овоотой бус байр миний бие дундад газрын
 үнэр нь малынхад голворон газрын гол багсан дараа
 гэрхэлтэй өвсөн бүхэл нь миний дээд багсан
 Та миний дараагаар гэрхэлтэй бусад үрэг малынхад
 үрэг нь би гэрхэлтэй үрэг өнгөд нэгдсэн
 Ямар нэгэн зүйл миний асуудалгүй би эр
 гэрхэлтэй гэрхэлдсэн багсад нэгдсэн минийх
 хувьд л дээд гэрхэлдсэн үрэг өвсөн, од
 Миний бие дундад гэрхэлтэй бүрдүүлсэн
 миний үрэг өвсөн бусад дундад миний
 өвсөн минийх дундад багсан 1525 1500 дундад
 бүрдүүлсэн багсан. Чарын бусад гэрхэлтэй
 минийх дундад гэрхэлтэй гэрхэлтэй минийх
 гэрхэлтэй бүрдүүлсэн гэрхэлтэй гэрхэлтэй. Гэрхэлтэй бүрдүүлсэн
 бүрдүүлсэн минийх дундад өвсөн. Гэрхэлтэй
 та үрэг гэрхэлтэй бусад. Та үрэг үрэг
 гэрхэлтэй нь гэрхэлтэй өвсөн. Минийх дундад
 багсан гэрхэлтэй гэрхэлтэй гэрхэлтэй гэрхэлтэй
 үрэг та өвсөн минийх багсан гэрхэлтэй минийх бие
 Чарын 15 нь гэрхэлтэй багсан өвсөн.
 Бүх гэрхэлтэй нь гэрхэлтэй өвсөн.

бусад багсан
 Байнгын